



**ДУНДМАНХАЙДАЙ
АУДИТ ХХК**

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Төмөрчний гудамж, Их найман шарга 10 давхар,
Утас: 9908-5151, 9199-1462, Факс: (976-11) 32-52-62,
E-mail: byambaahunnu@yahoo.com. <http://www.dumaudit.mn>

2024 03 04 № 15/01
танай _____-ны № _____-т

**“МАХ ИМПЕКС” ХК-ИЙН ТУЗ-ЫН
ДАРГА Г.ЦЭНГҮҮН БОЛОН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НАРТ**

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**Хүлээн авах хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот
Сонгинохайрхан дүүрэг 18100, 4-р хороо
Хүнчидийн гудамж, Өөрийн байр**

Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан

Дүгнэлт

Бид 2023 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн Мах Импекс ХК-ний санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар Мах Импекс ХК -ний 2023 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн орлогын дэлгэрэнгүй ба мөнгөн гүйлгээ, өмч өөрчлөлтийн тайлангууд нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Сангийн яамнаас батлан гаргасан заавар журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Бусад Мэдээлэл

Энэхүү компани нь бусад мэдээлэл буюу үйл ажиллагааны жилийн тайлан бэлтгэдэггүй. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй. Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай байлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ. Аудитын явцад бидэнд танилцуулаагүй баримт материалаас үүдэх эрсдлийг компанийн хариуцлага гэдгийг удирдлагад сануулсан болно.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсоолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээн Аудиторын Үүрэг Хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайлан бэлтгэх явдал юм.

Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу тайлагнал нь залилан эсвэл алдаанаас шалтгаалан үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Бид засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй аудитын хамрах цар хүрээ, цаг хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар компаниас ирүүлсэн баримт материалын хүрээнд илэрсэн дутагдал, зөрчлийн талаарх асуудлыг зөвлөмжөөр удирдлагад танилцуулан хүргүүлсэн болно.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү аудиторын тайланг Компанийн тухай хуулийн 94.1, 95.1 дүгээр зүйлүүдэд заасны дагуу компанийн удирдлага, хувьцаа эзэмшигчдэд зориулан бэлтгэсэн. Бид уг тайлангийг агуулгын хүрээнд аливаа нэг гуравдагч этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ ЧД 2 ХОРОО
БАКУЛА РИНБҮҮЧИЙН ГУДАМЖ
ОРШИЛ 2 ТӨВ 5 ДАВХАРТ

Огноо: 2024.03.04

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД
МАХ ИМПЕКС ХК

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	645,395,368.37	332,084,923.02
1.1.2	Дансны авлага	9,218,195,730.51	8,757,770,199.29
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	646,213,771.82	676,563,269.71
1.1.6	Бараа материал	13,437,854,950.47	21,833,497,535.06
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	2,038,608.77	2,038,608.77
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	23,949,698,429.94	31,601,954,535.85
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,664,051,076.75	3,322,541,398.73
1.2.2	Биет бус хөрөнгө	4,810,351.40	4,810,351.40
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,668,861,428.15	3,327,351,750.13
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	27,618,559,858.09	34,929,306,285.98
2.1.1.1	Дансны өглөг	20,293,862,010.26	24,586,645,230.54
2.1.1.2	Цалингийн өглөг	76,748,652.00	93,364,689.00
2.1.1.3	Татварын өр	97,209,731.35	391,377,345.74
2.1.1.4	НДШ-ийн өглөг	12,478,457.17	66,424,450.28
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	1,353,714,865.40	1,704,857,094.40
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	40,870,638.00	61,494,806.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	21,874,884,354.18	26,904,163,615.96
2.2	Өр төлбөрийн нийт дүн	21,874,884,354.18	26,904,163,615.96
2.3.2	Хувийн өмч	377,820,983.84	377,820,983.84
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,402,398,070.25	1,402,398,070.25
2.3.9	Хуримтлагдсан ашиг	3,963,456,449.82	6,244,923,615.93
2.3.11	Эздийн өмчийн дүн	5,743,675,503.91	8,025,142,670.02
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	27,618,559,858.09	34,929,306,285.98

АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/ төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	32,218,052,823.61	65,273,738,312.71
2	Борлуулалтын өртөг	30,036,524,171.40	61,751,025,840.58
3	Нийт ашиг (алдагдал)	2,181,528,652.21	3,522,712,472.13
4	Бусад орлого	3,856,831,805.68	3,549,542,524.97
5	Борлуулалт, маркетингийн зардал	243,984,175.51	489,936,679.64
6	Ерөнхий ба удардлагын зардал	1,874,672,629.84	890,061,508.54
7	Бусад зардал	2,686,583,533.99	2,693,221,131.68
8	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-1,645,142.14	-41,769,826.01
9	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,231,474,976.41	2,957,265,851.23
10	Орлогын татварын зардал	123,147,497.64	295,726,585.12
11	Татварын дараах ашиг (алдагдал)	1,108,327,478.77	2,661,539,266.11
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,108,327,478.77	2,661,539,266.11
13	Орлогын нийт дүн	1,108,327,478.77	2,661,539,266.11

АУДИТ ХИЙСЭН ӨМЧ ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөг/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	377,820,983.84	1,402,398,070.25	3,235,201,071.05	5,015,420,125.14
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	377,820,983.84	1,402,398,070.25	3,235,201,071.05	5,015,420,125.14
6	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	-380,072,100.00	-380,072,100.00
7	Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	1,108,327,478.77	1,108,327,478.77
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	377,820,983.84	1,402,398,070.25	3,963,456,449.82	5,743,675,503.91
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	377,820,983.84	1,402,398,070.25	3,963,456,449.82	5,743,675,503.91
12	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
13	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
14	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	-380,072,100.00	-380,072,100.00
15	Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	2,661,539,266.11	2,661,539,266.11
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
17	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	377,820,983.84	1,402,398,070.25	6,244,923,615.93	8,025,142,670.02

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	49,174,500,465.52	74,488,022,467.13
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	48,487,088,794.50	74,094,203,778.95
1.1.4	Буцаан авсан албан татвар	121,414,052.54	25,993,691.36
1.1.6	Бусад мөнгөн орлого	565,997,618.48	367,824,996.82
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-50,303,917,674.35	-74,788,441,691.48
1.2.1	Ажиллагчдад төлсөн	-1,382,114,620.00	-1,869,508,859.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-544,812,583.62	-535,652,404.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-46,268,692,406.93	-71,172,495,689.69
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	0.00	-60,000.00
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-10,268,430.00	-9,818,955.45
1.2.6	Хүүгийн тэлбэрт төлсөн	-1,028,634,731.53	-20,800,484.96
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-312,464,681.79	-215,669,549.54
1.2.9	Бусад мөнгөн зарлага	-756,930,220.48	-964,435,748.84
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,129,417,208.83	-300,419,224.35
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	523,213,990.28	60,532,000.18
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	523,213,990.20	60,532,000.18
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	523,213,990.28	60,532,000.18
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	991,646.65
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	0.00	991,646.65
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-73,955,320.85	-74,414,867.83
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-73,955,320.85	-26,816,253.00
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	0.00	-47,598,614.83
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-73,955,320.85	-73,423,221.18
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-680,158,539.40	-313,310,445.35
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,325,553,907.77	645,395,368.37
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	645,395,368.37	332,084,923.02

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН НЬ ДҮГНЭЛТ ТАЙЛАНГИЙН САЛШГҮЙ ХЭСЭГ БОЛНО.

ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК

ДУМ АУДИТ ХХК

